



ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭНИЙ ЗААЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2009 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Улаанбаатар хот

Дугаар 12

Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн хорооны 2007 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын Арван нэг дэх хэсгийн 11.1-д дор дурдсан агуулга бүхий хэсэг нэмсүгэй:

“...Түрээслэгч өөрчлөгдөөгүй тохиолдолд анх байгуулсан гэрээг үргэлжлүүлэн мөрдөх бөгөөд гэрээний нөхцөлийн талаар тохиролцож протокол үйлдэж сунгалтын хамт гэрээнд хавсаргана. Энэхүү протокол нь гэрээний салшгүй хэсэг байна.”

ДАРГА Д.СУГАР

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Л.ГАНБАТ

Улсын бүртгэлд 2009 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 3081 дугаарт бүртгэсэн

2009-01-21